



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/44

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны "2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 8/11/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шунхлай 5 дугаар багийн нутаг, Гуа хороолол наадмын талбайн урд байрлах 1,0 га газрыг Засаг даргын Тамгын газар (РД:9045562)-т Онцгой байдлын үед иргэд түр цуглах зориулалтаар 60 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Газар эзэмшүүлэхтэй холбогдсон бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлж, газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэхийг сумын Газрын даамал (Ц.Нямдорж)-д үүрэг болгосугай.
3. Газар эзэмших гэрээнд заагдсан зориулалтын дагуу зүй зохистой ашиглахыг Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ